



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Завхан-АЗЗА” ТӨХК-ийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 68,3 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн ТОГТООХ нь:

1. “Завхан-АЗЗА” ТӨХК-ийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Завхан-АЗЗА” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал М.Болдод үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг нэн даруй арилгах арга хэмжээ авах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллах;

2.3. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Б.ГАВАА



0000001

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын  
газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны  
өдрийн 12..дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /сая төг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөдөлмөр хамгааллын болон хангамжийн материал	Захирал М.Болд Ерөнхий Ня-бо Н.Ариунжаргал	68,3	Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-г мөрдэж ажиллах
	Дүн		68,3	